



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/263

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Архивын ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Архивын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



“АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН” 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитынтайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

САГазрын дарга: Ц. Наранчимэг
Утас:261663

Аудитын менежер:Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Б. Баярмаа
Утас: 260512

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын |Үбайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Юнистар” Аудит ХХК
Захирал: М.Энхжаргал
Утас:99168961328735
Цахим хаяг:
unistar_audit@yahoo.com
Аудитор:Т. Энхтуяа
Утас:96685259

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

САГазрын захирал: С.ЭнхзаяаТ
Утас:261663
Цахим хаяг:
enkhhappy@yahoo.com

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 261885
Цахим хаяг:

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын |Үбайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Ауулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан	2
2.1	Оршил	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.10	Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	11
3.1	Зардал	12
3.2	Бараа материал	13
3.3	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа.....	14
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл. Error! Bookmark not defined.	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Архивын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Архивын ерөнхий газрын дэд дарга, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Архивын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Архивын ерөнхий газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Архивын ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 01 дүгээрсарын 25-нд Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02/69 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт


Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 БАЙГУУЛЛАГЫНЗОРИЛГО,ҮЙЛАЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.



Архивын ерөнхий газар “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр үе шатыг 2017-2020 онд хэрэгжихээр төлөвлөн ажиллаж байна.

Архивын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Архивын ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
-

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журмын дагуу шинэчлэх шаардлагатай гэж үзэж зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Архивын ерөнхий газар төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Архивын ерөнхий газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянахүйл ажиллагаанд санхүүгийн “ACOLose” програм хангамж ашиглажээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Архивын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 6 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 5 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн байгууллагын хувьд материаллаг байдлын суурийг төсвийн зардлаар тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Архивын ерөнхий газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,714.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 114.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитаудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 50 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Аудитын явцад залруулга гараагүй.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	7.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	3	7.5	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

1.9.1 Зардал

Архивын ерөнхий газар дахин ашиглах боломжтой 12 нэрийн 7.5 сая төгрөгийн бараа материалыг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс нэрээр тайлант хугацааны зарлага болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 дугаар заалт "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Дахин ашиглах боломжтой бараа материалыг бүртгэлд тусгах, зөвлөмж өгөх

1.9.2 Бараа материал

Бараа материалыг зарлага болгохдоо зөвхөн шаардах хуудсаар болгодог бөгөөд зарлагын баримт үйлдэж баталгаажуулдаггүй байна.

Зөвхөн шаардах хуудас буюу хүсэлтээр бараа материалыг зарлага олгож байгаа нь анхан шатны баримтын иж бүрдэл, хүчин төгөлдөр байдалд нийцэхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн:

Бараа материалыг хуулийн хүчин төгөлдөр баримтаар зохих журмын дагуу зарлага болгох, зөвлөмж өгөх

1.9.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Архивын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр мөрдөж байгаа дансны код, төсвийн орлого, зарлагын ангилал, элэгдэл тооцох аргачлалтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. дах заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг оруулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм журам, холбогдох стандартад нийцүүлэн боловсруулж дагаж мөрдөх зөвлөмж өгөх

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудал гараагүй

1.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Архивын ерөнхий газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 3,698.6 сая, хөрөнгийн зардалд 3,908.5 сая

төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,607.1	6,671.8	-12.3	-935.3
1.1	Урсгал зардал	3,698.6	3,312.1	-10.45	-386.5
1.2	Хөрөнгийн зардал	3,908.5	3,359.7	-14.04	-548.8
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0		0.0
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,698.6	3,312.1	-10.4	-386.5
2.1	Улсын төсвөөс санхүүжих	3,534.6	3,312.1	-6.3	222.5
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл 935,3 сая төгрөг буюу 12,3 хувиар буурсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 29,1 сая, байр ашиглалттай тогтмол зардлыг 320,3 сая, хөрөнгийн зардлыг 548,8 сая төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 57,5 хувь буув 320,3 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь гэрэл цахилгааны 84,1 хувь буюу 296,1 сая, түлш халаалтын зардал 19,7 хувь буюу 18,9 сая, цэвэр бохир усны зардал 19,4 хувь 5,3 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Дээрх зардлууд хэмнэгдсэн шалтгаан нь төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй, урсгал болон хөрөнгийн санхүүжилтийг бүрэн хийгээгүйтэй холбоотой байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Архивын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Архивын ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Архивын ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



“АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР”

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 1

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 1

Бараа материалын талаар.....3

Асуудал 2

Өөрийн орлогын талаар.....5

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Архивын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

2.1 Зардал

Илрүүлэлт

Архивын ерөнхий газар дахин ашиглах боломжтой 12 нэрийн 7.5 сая төгрөгийн бараа материалыг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс нэрээр тайлант хугацааны зарлага болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 дугаар заалт "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах

Зөвлөмж

Бараа материалыг зарлага болгохдоо дахин ашиглах болон чанар байдал, үнэ цэнийг харгалзан үзэж зарлага болгохоос гадна ажил гүйлгээг бодитой зөв үнэлж, нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

2.2 БАРАА МАТЕРИАЛ

Илрүүлэлт

Бараа материалыг зарлага болгохдоо зөвхөн шаардах хуудсаар болгодог бөгөөд зарлагын баримт үйлдэж баталгаажуулдаггүй байна.

Зөвхөн шаардах хуудас буюу хүсэлтээр бараа материалыг зарлага олгож байгаа нь анхан шатны баримтын иж бүрдэл, хүчин төгөлдөр байдалд нийцэхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дүгээр зүйлт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэсэн заалтын үндэслэн бараа материалыг зарлага болгохдоо дахин ашиглах боломж болон чанар байдал, үнэ цэнийг харгалзан үзэж зарлага болгохоос гадна ажил гүйлгээг бодитой зөв үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Архивын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр мөрдөж байгаа дансны код, төсвийн орлого, зарлагын ангилал, элэгдэл тооцох аргачлалтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2. дах заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг оруулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг зөрчиж байна.

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2 дугаар зүйл "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг эрх бүхий байгууллагаас шинээр батлан гарсан бодлого, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталгааулах.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

Өмч хөрөнгө зүй бусаар зарцуулагдах

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	215,292,946.29	764,975,789.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,136,552.00	548,790,800.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,013,552.00	-
31110	Төгрөг	2,013,552.00	
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,123,000.00	548,790,800.00
3121	Төгрөг	12,123,000.00	548,790,800.00
31211	Төрийн сангийн харилцах		548,775,000.00
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	12,123,000.00	15,800.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
33	АВЛАГА	21,710,000.00	40,980,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	21,710,000.00	40,980,000.00
3351	Байгууллагаас авах авлага	21,710,000.00	40,980,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
34	УРЬДЧИЛГАА	9,503,000.00	-
34100	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
34200	Төсөвт байгууллага		
34300	Тусгай зориулалтын сан		
34400	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
34500	Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар		
34600	Урьдчилж гарсан зардал		
3471	Урьдчилгаа тооцоо	9,503,000.00	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	9,503,000.00	
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		
34713	Цалингийн урьдчилгаа		
34714	Томиолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	169,943,394.29	175,204,989.49
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	169,943,394.29	175,204,989.49
35410	Бичиг хэргийн материал	65,004,364.30	60,347,058.30
35420	Аж ахуйн материал	65,675,029.99	107,508,931.19
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	39,264,000.00	7,349,000.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,310,986,416.86	17,287,069,865.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,310,986,416.86	17,287,069,865.12
391	Газар		
392	Биет хөрөнгө	15,296,905,334.20	17,254,057,990.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,479,368,100.00	13,554,248,819.00

39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,425,035,787.70)	(768,906,455.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,257,700.00	234,057,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,175,428.46)	(203,480,184.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	562,913,512.00	4,276,674,108.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(296,902,659.41)	(394,357,398.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	521,482,014.00	880,082,369.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(247,259,598.23)	(327,494,229.70)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39216	Дуусаагүй барилга, байгууламж	12,671,024,219.00	
39217	Ном	3,233,263.00	3,233,263.00
393	Биет бус хөрөнгө	14,081,082.66	33,011,874.60
39301	Програм хангамж	66,271,666.00	86,571,666.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(52,190,583.34)	(53,559,791.40)
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/		
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,526,279,363.15</u>	<u>18,052,045,654.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>960,000.00</u>	<u>549,735,000.00</u>
